

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 21 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Төлбөрийн акт	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.08.25 № 63

танай _____-ны № _____-т

ДАРХАН СУМЫН 21 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.ЭНХТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 21 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 21 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Боловсролын газраас бүх цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан хэрэгцээт багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд тус байгууллага нь хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүн худалдан авах төлөвлөгөөнд тусгагдаагүй бүтээгдэхүүн худалдан авч хоол үйлдвэрлэлд зарцуулсан, худалдан авалтын гэрээг байгуулахдаа нэгж үнэ, тоо ширхэг, бүтээгдэхүүний нэр төрлийг хавсаргаж баталгаажуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

4528050147

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 21 дүгээр цэцэрлэг нь 2025 онд 4 зорилт 103 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 89.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	324,083,986.70	135,022,056.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	249,596,591.16	20,256,880.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	249,596,591.16	20,256,880.16
31211	Төрийн сангийн харилцах	249,596,591.16	20,256,880.16
35	БАРАА МАТЕРИАЛ	74,487,395.54	114,765,176.27
351	Түүхий эд материал	1,082,890.00	1,084,040.00
35130	Эм боох материал	1,082,890.00	1,084,040.00
354	Хангамжийн материал	73,404,505.54	113,681,136.27
35410	Бичиг хэргийн материал		250,000.00
35420	Аж ахуйн материал	55,370,195.54	98,641,755.27
35450	Барилгын засварын материал	1,548,800.00	5,998,800.00
35460	Хүнсний материал	16,485,510.00	8,790,581.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,490,345,725.65	1,454,072,255.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,490,345,725.65	1,454,072,255.92
392	Биет хөрөнгө	1,041,170,958.97	1,005,047,395.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,156,895,159.20	1,156,895,159.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(233,784,037.14)	(273,392,049.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,545,996.00	84,495,820.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,552,766.56)	(23,092,414.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,929,066.00	57,925,990.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,870,341.58)	(18,366,423.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,719,424.58	29,719,424.58
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,488,992.60)	(9,138,109.44)
39217	Ном	2,777,451.07	-
393	Биет бус хөрөнгө	449,174,766.68	449,024,860.04
39301	Програм хангамж	449,720.00	449,720.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(74,953.32)	(224,859.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	448,800,000.00	448,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,814,429,712.35	1,589,094,312.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,914,102.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,914,102.12
413	Өглөг	-	1,914,102.12
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		1,914,102.12
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,814,429,712.35	1,587,180,210.23
51	Засгийн газрын хувь оролцоо	1,814,429,712.35	1,587,180,210.23
511002	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	797,596,927.00	797,596,927.00
512	Хуримтлагдсан үр дүн	(23,355,935.36)	(250,605,437.48)
51210	Өмнөх үеийн үр дүн	(23,355,935.36)	(23,355,935.36)
51220	Тайлант үеийн үр дүн		(227,249,502.12)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,040,188,720.71	1,040,188,720.71
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,814,429,712.35	1,589,094,312.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,530,027,920.00	1,410,468,427.07
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,651,820.00	88,810,427.07
120	Нийтлэг татварын бус орлого	78,651,820.00	88,810,427.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,410,320.00	9,882,720.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,410,320.00	9,882,720.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	33,241,500.00	30,929,360.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	47,998,347.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,451,376,100.00	1,321,658,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,391,021,500.00	1,259,077,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,391,021,500.00	1,259,077,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,354,600.00	62,580,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,354,600.00	62,580,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,344,341,068.69	1,628,499,529.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,344,341,068.69	1,628,499,529.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,343,957,090.81	1,628,225,925.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	918,806,302.29	1,152,187,510.00
210101	Үндсэн цалин	620,057,874.29	734,999,430.32
210102	Нэмэгдэл	274,933,758.00	346,620,095.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт		38,029,349.00
210104	Урамшуулал	23,814,670.00	32,538,635.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,175,178.19	145,204,092.12
210201	Тэтгэврийн даатгал	80,780,295.83	99,116,692.12
210202	Тэтгэмжийн даатгал	9,377,744.57	11,521,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,676,824.61	5,760,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,468,059.44	5,760,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,872,253.74	23,043,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,470,699.12	53,341,846.88
210301	Гэрэл, цахилгаан	11,179,999.53	15,050,392.52
210302	Түлш, халаалт	20,367,708.24	18,784,642.36
210303	Цэвэр, бохир ус	15,922,991.35	19,506,812.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,719,310.46	38,604,467.34
210401	Бичиг хэрэг	10,487,450.00	14,696,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	220,000.00	1,210,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,297,450.00	7,789,010.00
210408	Бараа материал актальсны зардал	9,444,410.46	14,549,157.34
2105	Нормативт зардал	143,372,137.50	150,582,179.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	678,012.50	927,260.00
210502	Хоол, хүнс	142,694,125.00	149,654,919.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,334,903.00	6,577,210.00
210604	Урсгал засвар	13,334,903.00	6,577,210.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,292,200.00	6,509,041.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	357,200.00	907,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,935,000.00	5,601,841.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,786,360.25	75,219,579.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,102,190.00	7,352,430.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,882,130.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,802,040.25	67,867,149.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	383,977.88	273,603.12
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	383,977.88	273,603.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	383,977.88	273,603.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	185,686,851.31	(218,031,102.01)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,218,400.11

225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	9,218,400.11
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(9,218,400.11)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	185,686,851.31	(227,249,502.12)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,451,376,100.00	1,321,658,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,451,376,100.00	1,321,658,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,391,021,500.00	1,259,077,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,391,021,500.00	1,259,077,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,354,600.00	62,580,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,354,600.00	62,580,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,290,096,420.48	1,550,997,711.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,290,096,420.48	1,550,997,711.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,289,712,442.60	1,550,724,107.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	918,806,302.19	1,152,187,500.00
210101	Үндсэн цалин	620,057,874.19	734,999,420.32
210102	Нэмэгдэл	274,933,758.00	346,620,095.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт		38,029,349.00
210104	Урамшуулал	23,814,670.00	32,538,635.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,175,178.29	143,290,000.00
210201	Тэтгэврийн даатгал	80,780,295.93	97,202,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,377,744.57	11,521,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,676,824.61	5,760,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,468,059.44	5,760,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,872,253.74	23,043,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,470,699.12	53,341,846.88
210301	Гэрэл, цахилгаан	11,179,999.53	15,050,392.52
210302	Түлш, халаалт	20,367,708.24	18,784,642.36
210303	Цэвэр, бохир ус	15,922,991.35	19,506,812.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		120,000.00
2105	Нормативт зардал	148,168,890.00	141,959,990.00
210502	Хоол, хүнс	148,168,890.00	141,959,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,499,923.00	8,964,850.00
210604	Урсгал засвар	12,499,923.00	8,964,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,380,000.00	6,932,841.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,380,000.00	6,932,841.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,211,450.00	43,927,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,739,950.00	31,118,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,471,500.00	12,809,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	383,977.88	273,603.12
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	383,977.88	273,603.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	383,977.88	273,603.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	161,279,679.52	(229,339,711.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	161,279,679.52	(229,339,711.00)

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88,316,911.64	249,596,591.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	249,596,591.16	20,256,880.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	797,596,927.00	1,040,188,720.71	(209,042,786.67)	1,628,742,861.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	797,596,927.00	1,040,188,720.71	(209,042,786.67)	1,628,742,861.04
Тайлант үеийн үр дүн	-	-	185,686,851.31	185,686,851.31
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	797,596,927.00	1,040,188,720.71	(23,355,935.36)	1,814,429,712.35
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	797,596,927.00	1,040,188,720.71	(23,355,935.36)	1,814,429,712.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	797,596,927.00	1,040,188,720.71	(23,355,935.36)	1,814,429,712.35
Тайлант үеийн үр дүн	-	-	(227,249,502.12)	(227,249,502.12)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	797,596,927.00	1,040,188,720.71	(250,605,437.48)	1,587,180,210.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,505,208,700.00	1,488,417,411.00	16,791,289.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,505,208,700.00	1,488,417,411.00	16,791,289.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,505,208,700.00	1,488,417,411.00	16,791,289.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,152,187,500.00	1,152,187,500.00	-
210101	Үндсэн цалин	786,054,600.00	734,999,420.32	51,055,179.68
210102	Нэмэгдэл	338,734,200.00	346,620,095.68	(7,885,895.68)
210103	Унаа хоолны хөнгөлөлт		38,029,349.00	(38,029,349.00)
210104	Урамшуулал	27,398,700.00	32,538,635.00	(5,139,935.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,290,000.00	143,290,000.00	-
210201	Тэтгэврийн даатгал	97,202,600.00	97,202,600.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	11,521,900.00	11,521,900.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,760,900.00	5,760,900.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	5,760,900.00	5,760,900.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	23,043,700.00	23,043,700.00	-
2105	Нормативд зардал	158,673,700.00	141,959,990.00	16,713,710.00
210502	Хоол хүнс	158,673,700.00	141,959,990.00	16,713,710.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,933,200.00	6,932,841.00	359.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-		-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	6,933,200.00	6,932,841.00	359.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,124,300.00	44,047,080.00	77,220.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,315,300.00	31,238,080.00	77,220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,809,000.00	12,809,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,505,208,700.00	1,259,077,700.00	12,543,200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,271,620,900.00	1,259,077,700.00	12,543,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,271,620,900.00	1,259,077,700.00	12,543,200.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	233,587,800.00	233,587,800.00	-
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	233,587,800.00		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	249,596,591.16	(249,596,591.16)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,256,880.16	(20,256,880.16)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,455,800.00	62,580,300.00	9,875,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,455,800.00	62,580,300.00	9,875,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,455,800.00	62,580,300.00	9,875,500.00
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	63,455,800.00	53,341,846.88	10,113,953.12
210301	Гэрэл, цахилгаан	16,975,000.00	15,050,392.52	1,924,607.48
210302	Түлш халаалт	28,736,400.00	18,784,642.36	9,951,757.64
210303	Цэвэр, бохир ус	17,744,400.00	19,506,812.00	(1,762,412.00)
2106	ЭД ХОГШИЛ, УРСГАЛ ЗАСВАРЫН ЗАРДАЛ	9,000,000.00	8,964,850.00	35,150.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	8,964,850.00	35,150.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		273,603.12	(273,603.12)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,455,800.00	62,306,396.88	10,149,403.12
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,455,800.00	62,306,696.88	10,149,103.12

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,744.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Г.Энхтулгын сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5-д *“Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”*, 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан *“Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”*-ын хавсралт *“Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”*-ын 3-д *“Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч Г.Энхтулга нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д *“Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”*, 16.5.1-д *“Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”*, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д *“Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”*, 27.6-д *“Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”*, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт *“Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд тус цэцэрлэгийн бараа, үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч М.Энхмаад сургалтын төлбөр төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлс авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй	1	2,144.0	-	-	1	2,144.0	-	-	-	-	
Дүн	2	2,744.0	1	600.0	1	2,144.0	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хүүхдийн хоол хүнсний худалдан авалтын гэрээнд нэгж үнийг хавсаргаж баталгаажуулаагүй, тайлант хугацааны эцэст гэрээ дүгнэж акт үйлдээгүй байна.	1	141,959.9			1	141,959.9		
Дүн	1	141,959.9	-	-	1	141,959.9	-	-